

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.12.02

Дархан-Уул аймаг

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5, 7 дугаар зүйл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн 2021 оны тогтоол, Соёлын сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/85 дугаар тушаал, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн З/1298 тоот, Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/866 тоот албан бичгийн дагуу Дархан-Уул аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулагдсан.

Залуучуудын хөгжил оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг тус зөвлөл нь 2023 онд нийт **7 ажил** зохион байгуулахаар төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Үүнд:

1. **Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн хурал:** 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл оны анхдугаар хурлаа хийж зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгууллаа. Тус онд улирал бүр нийт 4 удаагийн хурлыг зохион байгуулж ажиллав.



**Зураг-1.** Зөвлөлийн даргаар Залуучууд театрын менежер Ц.Баттөмөр сонгогдож байгаа нь.

2. **“Өв соёлоо өвлөн уламжлагч” сургалт:** Дархан-Уул аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлөөс санаачлан мартагдаж буй өв соёлоо сэргээх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор **“Өв соёлоо өвлөн уламжилъя”** Зүү ороох хатгамлын сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Дархан сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн **20** сурагчийг хамруулан эхлүүлж нэг сарын турш үргэлжлүүлэв.

Тус сургалтад ашиглагдах зүү, утас зэрэг сургалтын хэрэглэгдэхүүн, даалингийн материал зэрэг нийт 1.0 сая төгрөгийн дэмжлэгийг Дархан сумын ЗДТГ-аас үзүүлсэн юм. Нэг сарын сургалтын дараагаар хүүхдүүд өөрсдийн оёсон бүтээлээр үзэсгэлэн гаргаж тайлагнав.



**Зураг-2.** Тус сургалтыг зохион байгуулахад Дархан сумын ЗДТГ, аймгийн Соёл, урлагийн газраас дэмжин ажиллалаа.



**Зураг-3.** Сургагч багшаар Дархан-Уул аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүлэх гишүүн, Сэтгэмж урлангийн уран хатгамалч, 3 дахь үеийн өвлөн уламжлагч Ж.Батцэцэг ажиллалаа.

**3. Хаврын баяр бүжгийн наадам буюу “Darkhan dance festival 2023” бүжгийн анхдугаар уралдааныг** 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Соёл, урлагийн газар, Залуучууд театр, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар хамтран зохион байгууллаа. Бүжгийн уралдаанд нийт 5.0 сая төгрөгийн дэмжлэгийг Дархан сумын ЗДТГ-аас үзүүлсэн юм.

Бүжгийн анхдугаар уралдааныг тус аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүн, Залуучууд театрын дуучин, МУСТА С.Соронзонболд, зөвлөлийн гишүүн, Монголын бүжгийн нэгдсэн холбооны тэргүүн Амармэнд нар хариуцан зохион байгуулав.






4. **Уран зургийн үзэсгэлэн:** Дархан-Уул аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүн, Дарханы зураач урчуудын эвлэлийн тэргүүн зураач, СТА Н.Хишигбаатар нарын залуу зураачид төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уран зургийн цуврал үзэсгэлэнг толилуулав. Үүнд:

-2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зураач С.Мөнгөнзулын анхны бие даасан уран бүтээлийн "ГҮНЖ" үзэсгэлэнг 10 хоногийн хугацаанд Дарханчуудад толилуулав.



-2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр залуу зураач Б.Жаргалсайхан "ART OF N" уран бүтээлийн үзэсгэлэнг 54 бүтээлээр дэлгэлээ.



-2023 оны 05 дугаар сарын 28-ний өдөр D-art урлангийн багш, залуу зураач Ч.Нарангарав зураач хүүхдүүйнхээ бүтээлээр үзэсгэлэн гаргаж бүтээлийн дээжээс Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасагт бэлэглэлээ.



-2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Соёлын салбарын Залуучуудын зөвлөлийн гишүүн, Дарханы зураач урчуудын эвлэлийн тэргүүн зураач, СТА Н.Хишигбаатар “Монгол авдар”-ны үзэсгэлэнг Эмэгтэйчүүдийн ордонд 7 хоногийн турш гаргасан юм.



-“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Дархан-Уул аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүн, Дарханы зураач урчуудын эвлэлийн тэргүүн, СТА Н.Хишигбаатар Дарханы зураач урчуудын 22 уран бүтээлчдийн “Мэдрэмж” уран зургийн үзэсгэлэнг 2023 оны 11 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд Залуучууд театрт зохион байгуулж ажиллалаа. Тус үзэсгэлэнд 17-18 насны хүүхдүүд соёлын эрхийн бичгээр хамрагдав.



**5. Залуучуудын хөгжлийн сарын хүрээнд “Соёлын салбар дахь залуучуудын оролцоо” хэлэлцүүлэг:** - 2023 оны 08 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Шарын гол суманд залуучуудад зориулсан өдөрлөг, цугларалтыг зохион байгуулж залуусын дуу хоолой, санал санаачилгыг шийдвэр гаргах түвшинд хүргүүлэв.



-Шарын гол сумын Соёлын төвтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр “Хүүхэд-Асуудал-Гарц-Шийдэл” анхдугаар хэлэлцүүлгийг Шарын гол сумын ЕБ-ын 2, 6 дугаар

сургуулийн сурагчид, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, төрийн байгууллагын төлөөлөл зэрэг 200 гаруй иргэд, олон нийтийн дунд зохион байгууллаа.



6. Сан байгуулах: D-art продакшн, Дархан-Уул аймгийн Дуучдын зөвлөлтэй хамтран сан байгуулах ажлыг эхлүүлсэн. Ингэснээр Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь соёлын оролцоот олон талт үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулах боломж бүрдэх юм.

7. “Эрин зууны Дархан” тоглолт: Дархан хотын уламжлалт соёлын арга хэмжээг бий болгох зорилгоор Дархан хотноо үйл ажиллагаа явуулж буй болон Дархан хотоос гаралтай хамтлаг, дуучдыг нэгтгэсэн тоглолтыг 2023 оны 09 дүгээр сарын 23-нд Дархан сумын 3 дугаар баг, Наадмын талбайд зохион байгууллаа.

 A promotional poster for the "Banger Night DARKHAN" event. The poster features a collage of young people's faces. Text on the poster includes:
 

- Date: 16 Sept 16.09.2023
- Time: OPEN DOOR 14:00
- Event Name: ЭРИН ЗУУНЫ ДАРХАН
- Headline: БАНГЕР НАЙТ ДАРХАН
- Artists: DESANT, THUNDERZ, O.Z, BILGANG, VANDEBO, DON DIOR, PACRAP, WOLFIZM, MAARAA, 290, LIMIT KING, GVNSOR, YOUNG SUB, BABYNNA
- Comedian: BEEGII / COMEDIAN
- Sponsors: SPONSORED BY ДАРХАН-УУЛ АЙМАГ, ДАРХАН СУМ, ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР, ЗАЛУУЧУУД ТЕАТР, ГРАНД ЯК ХХК, АПУ ХК

Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2023 оны төлөвлөгөөт ажлаас гадна Үндэсний их баяр наадам, Дархан хотын ойн өдөр, Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Соёлын ажилтны өдөр, Соёлын сэргэлт 2023 аян, Соёлын бүтээлч сар зэрэг томоохон баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, аян арга хэмжээг зохион байгуулахад дайчлагдан ажиллаж ирсэн болно.

ТАЙЛАН БИЧСЭН:  
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА